

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.08.17, ПҮРЭВ ~ №154 (700)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгч Х.Баттулга бизнесийн ажил хэрэгч харилцааг чухалчлав.
УИХ-ын гишүүнд нэр дэвших насны босгыг нэмэгдүүлэх санал гаргажээ.
Засгийн газрын ээлжит хуралдаан хойшилж, өнөөдөр болно.
Ардчилсан намын Зүүн бүсийн чуулга уулзалт Хэнтий аймагт боллоо.
МАН-ын УЗ хуралдаж, дотоод асуудлаа хэлэлцсэн ч албан ёсны мэдээлэл өгсөнгүй.

ЭДИЙН ЗАСАГ

Монголын хөрөнгийн биржийн "MSE ALL" индекс 0.65 хувиар өсөв.
Эдийн засгийн идэвхтэй хүн амын 60.9 хувь нь хот, суурин газарт амьдарч байна.
Банкны чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.8 хувийг эзэлж байна.
БНХАУ-ын 2020 он хүртэлх өсөлтийн төлөвийг ОУВС нэмэгдүүлж, 6.4 хувь болгов.
"Ремикон" хоёрдугаар улиралд 870.7 орчим сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

НИЙГЭМ

Богдхан уулын ойн сангийн 76 хувь хөгширсөн тул цэвэрлэх шаардлагатай гэв.
Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт 77.6 хувьд хүрнэ.
Дэлхийн 40 орчим орны 200 гаруй яруу найрагч, зохиолчид Монголд чуулж байна.
Өмнөговьд малын шилжилт хөдөлгөөнийг гурван жилийн хугацаатайгаар хориглолоо.
АТГ өнгөрсөн долоо хоногт 148 нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянав.

ДЭЛХИЙ

Грек улс ойн түймэртэй тэмцэхэд ЕХ-ноос тусламж хүслээ.
АНУ-д Дональд Трампын твит бичлэгийн зурагт товхимол хэвлэгдэн гарлаа.
БНХАУ дэлхийд хамгийн том, хөвдөг нарны цахилгаан станц байгууллаа.
БНСУ-ын компаниудын хувьцааны гуравны нэгийг гаднынхан эзэмшдэг.
Мельбурн амьдрахад хамгийн таатай хотоор долоо дахь удаагаа шалгарлаа.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2017.08.17



26° 14°

ТҮР ЗУУРЫН БОРООТ

ЦАГ АГААРЫН ДЭГЖЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙГ 6 ДУГААР НҮҮРЭЭС ҮШИНЭВ. УУ



8658004029112 0 0 7 0 0

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Хар тахал хаалга тогшсон хэвээр



Хүн төрөлхтний түүхэнд тохиолдсон халдварт өвчнөөс хамгийн олон хүний амийг авч одсон нь тарваган тахал. Улсын хэмжээнд 17 аймгийн 157 сум тарваган тахлын голомттой гэж бүртгэгджээ. >3

ЗГМ ©

БИ ҮЙЛДВЭРЛЭГЧ

Тансаг хэрэглээний шинэ загвар

АНУ-д модон ванн 8000 ам.долларын үнэтэй байдаг

Б.Бямбасүрэн
@byambaZGM

Монголд төдийгүй орон нутагт тансаг зэрэглэлийн модон ванн үйлдвэрлэж, АНУ-ын зах зээлд борлуулж буй эрхэмийг энэ удаагийн "Би үйлдвэрлэгч" буланд олон олох болно. Тэрбээр АНУ-ын иргэн бөгөөд коллежийн оюутан байхдаа модон завь хийхээр оролдож, улмаар ванн урласан байна. Ингээд модон ванн үйлдвэрлэх бизнесийн санаа төрж, Waterwood компанийг үүсгэн байгуулжээ. Баян-Өлгий аймагт гэр бүлийн

хамт ажиллаж, амьдарч үйлдвэрлэлээ өргөжүүлж буй Waterwood компанийн захирал Тэйлор Росстой ярилцлаа. Тэрбээр Монголд эдийн засгийн хүндрэлтэй байгаа ч удахгүй тансаг зэрэглэлийн модон ванн худалдах зах зээл бий болж, хэрэглэгчдэд хүрнэ гэдгийг онцоллоо.

-Монголд эрхэлж байгаа үйлдвэрлэлийнхээ талаар танилцуулахгүй юу. Модон ванн үйлдвэрлэх бизнесийн санаагаа хэрхэн олсон бэ. Яагаад энэ зах зээлийг сонгох болов?
-Анх коллежийн оюутан байхдаа ванн хийх санааг санамсаргүй олж байлаа. Модон каяк завь хийх гэж оролдож байгаад, эцэстээ ванн шиг хэлбэртэй болчихсон.

>5

FT Бондын өгөөж буурч үнэ өсөж байна

Кейт Аллен, Кейт Фрей

Томоохон төв банкууд Засгийн газруудынхаа нийт өрийн бичгийн тавны нэгийг эзэмшиж байгаа нь сүүлийн арван жилд хэрэгжүүлсэн мөнгөний өргөн хүрээтэй бодлогоос үүсэх бэрхшээлийн түвшинг харуулж байна. Санхүүгийн хямрал эхэлснээс хойш дэлхийн хамгийн том төв банкууд эдийн засгийн сэргэлтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор их хэмжээний бонд болон бусад үнэт цаас худалдан авч, өрхийн болон бизнесийн зээлийн өртгийг бууруулсан билээ.


АНУ-ын Холбооны нөөц, Европын төв банк, Японы банк, Английн банк болон Швейцар, Шведийн төв банк, нийт 15 их

наяд ам.долларын үнэт цаас эзэмшиж байгаа нь санхүүгийн хямралын өмнөхөөс дөрөв дахин их байгааг ОУВС-гийн судалгаанд дурджээ. Үүнээс өсөн их наяд нь Засгийн газрын бонд агаад эдгээр улсын Засгийн газрын нийт 46 их наяд ам.долларын өрийн таван доллар тутмын нэгийг эзэмшиж байна гэсэн үг. Европын төв банкны ам.доллараар тооцсон тэнцлийн хэмжээ саяхан Холбооны нөөцийнхөөс давсан.

Тус банк 4.9 их наяд ам.долларын хөрөнгөтэй ба хоёр их наяд нь евро бүсийн Засгийн газруудын бонд юм.

>7

ЗГМ: ИНФОГРАФИК



ЭДИЙН ЗАСАГ Хөрөнгө оруулалтын хүч

Б.Баяртөгтох
@bayartogtkhZGM

Төлбөрийн тэнцлийн хоёрдугаар улирлын гүйцэтгэлийг Монголбанкнаас танилцууллаа. Эдийн засгийн "эрүүл мэнд"-ийг тодорхойлох статистик үзүүлэлт дөнгөж гаргасан талх шиг халуун байна. Төлбөрийн тэнцэл 74 сая ам.долларын алдагдалтай гарчээ. Энэ нь таамаглаж байснаас хавьгүй бага дүн. Алдагдлын хэмжээг оны эхний улиралтай харьцуулахад хоёр дахин буурсан үзүүлэлттэй гарав. Энэ оны нэгдүгээр улиралд төлбөрийн тэнцэл 163.7 сая ам.долларын алдагдал байсан. Харин хоёрдугаар улиралд алдагдал ийнхүү хумигджээ. Гэхдээ 74 сая ам.доллараас бага алдагдал хүлээх боломж бас байсан.

Учир нь, энэ оны зургадугаар сард төлбөрийн тэнцэл 35.6 сая ам.долларын алдагдал хүлээсэн. Харин хоёрдугаар улирлын гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн алдагдал 38.4 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Шалтгаан нь ОУВС-гийн Ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу тус сангаас авсан зээлийн бүртгэлийг Засгийн газраас Монголбанк руу шилжүүлсэнтэй холбоотой аж. Хэрэв төв банк руу зээлийн бүртгэлийг шилжүүлээгүй бол алдагдлын мөнгөн дүн 30 сая ам.доллараар тэлэхгүй байлаа. Хэдий ийм боловч Монгол Улсын төлбөрийн тэнцэл 74 сая ам.долларын алдагдалтайгаар гуравдугаар улиралтай золгов.

>8

MSE ALL	АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	5-ЧИНГИС БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
925.75 0.65%	1269.00 2.10%	6411 0.19%	96.98 0.06%	100.33 0.06%	2444.19	366.13	40.96

Нийтлэлчийн булан

Хар тахал хаалга тогшсон хэвээр


Зургаан аймагт тарваган тахлын байгалийн голомт онц идэвхтэй байна

Г.Баярсайхан
@BayarsaikhanZGM

Онцгой байдлын алба хаагчдын өмнө тулгарах элдэв бэрхшээл дуусахгүй. Тэд хавар, зуны турш түймэр, үер усны аюултай тэмцсээр одоо л нэг уужим амьсгаа авахтайгаа болсон. Гэвч залгуулаад элдэв халдварт өвчний дэгдэлт дахин сэргэж, албаныхныг сандаргах үе ирлээ. Ялангуяа наймдугаар сар бол тарваган тахлын дэгдэлтийн оргил үе. Тиймээс мэргэжлийн хяналт, онцгой байдал, Зоонозын өвчин судлалын төв гээд мэргэжлийн байгууллагууд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажилд ханцуй шамлан оржээ.

Халдвар авсан даруйд нэн яаралтай эмнэлгийн байгууллагад хандахгүй бол амь насыг нь өршөөлгүйгээр авч оддог энэ аюулт өвчин монголчуудын танил болсон түүх их эртнийх. Бүр 1800-гаад оны дундуур гаднын эрдэмтэд тахлын нян Монголд байж магадгүй гэсэн таамаг дэвшүүлж байв. Харин 1911 онд Оросын шинжилгээний баг өвчтэй тарваганаас нян илрүүлсэнээр таамаг төдий байсан аюул дэргэд нэгэнт ирснийг нотолжээ.

Өнгөрсөн жилүүдэд бид тахалтай удаа дараа нүүр тулж, ялж, ялагдаж ирсэн. 1940-өөд оны сүүл, 1950-иад оны эхээр дэгдэлт оргилдоо хүрсэн түүхтэй. Тухайлбал, 1949 онд 37 тохиолдол бүртгэгдсэнээс 34 хүн амиа алдсан юм. Энэ үеэс хойш хөнөөлт тахлын дэгдэлт аажмаар буурсаар байгаа. Өнгөрсөн хоёр жил улсын хэмжээнд тахлаар буурсаар байгаа. Өнгөрсөн хоёр жил улсын хэмжээнд тахлаар хүн нас барсан тохиолдол бүртгэгдээгүй нь түүнтэй хийх тэмцэл үр дүнгээ өгсний илэрхийлэл. Гэхдээ тайвшрахад



эрт байна. Аюул биднийг одоо ч отсоор байгаа. Үүнийг дараах хэдэн шалтгаанаар тодотгоё.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн мэргэжилтнүүд өнгөрсөн долдугаар сард тахлын голомт бүхий бүс нутагт тандалт, судалгаа хийгээд иржээ. Дээрх судалгаагаар Баян-Өлгийн Ногооннуур, Улаанхус, Цагааннуур, Бугат, Ховдын Булган, Мөст, Алтай, Өвөрхангайн Хайрхандулаан, Уянга, Сант, Завханы Эрдэнэ-хайрхан, Төв аймгийн Сэргэлэн сум, Хөвсгөлийн зарим нутагт тарваган тахлын байгалийн голомт онц идэвхтэй, мэргэч амьтдын дунд тахлын өвчлөл явагдаж байгаа нь тогтоогдсон байна. Эдгээр нутагт тарвага агнаж идвэл халдвар авах магадлал маш өндөр гэсэн үг. Ер нь улсын хэмжээнд 17 аймгийн 157 сум тарваган тахлын голомттой гэж бүртгэгджээ. Бараг нийт сумдын тал шахам хувьд нь тахлын тохиолдол илэрч байсан гэж бодохоор айдас төрөхөөс аргагүй.

“Мэргэч амьтдын өвчлөл явагдах эрсдэл хамгийн өндөр үе бол наймдугаар сар. Тиймээс мэргэжлийн байгууллагууд урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хийдэг. Эрсдэлтэй

бүс нутагт байгаа хүмүүсийг вакцинд хамруулах нь үр дүнтэй арга. Энэ жил улсын хэмжээнд вакцинжуулалт 80 гаруй хувьтай хийгдсэн тухай мэдээ ирсэн. Вакцин хийлгэснээр бүтэн жилийн дархлаа тогтоно.

Тарвага агнахыг хориглосон ч тоо толгой нь эрс багасчээ

Хамгийн гол нь иргэд сэргэмжлүүлэг, анхааруулгыг бүрэн мөрдөж чадвал тахлаас урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой” хэмээн Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн тархвар судлагч их эмч Д.Отгонбаяр хэлэв. Мэргэжлийн хүн ийн анхааруулсан ч иргэд тарваганаас татгалзаж чадалгүй хулгайгаар агнаж, зооглосоор байна. Энэ хэрээр тахал дэгдэх эрсдэл нэмэгдэх нь мэдээж.

Уг нь манай улс 2014 онд тарвага агнахыг хуулиар хориглосон. Агнахгүй болохоор тоо толгой нь өсөх ёстой. Гэвч гадаадын амьтан судлалын байгууллагын хийсэн судалгаа тийм

биш гэдгийг нь нотлоод өгөв. Тухайлбал, 1990 онд 20 саяд хүрч байсан тарваганы тоо толгой өдгөө 75 хувиар буурсан тухай цочирдом мэдээ дэлгэж байв. Хориглосон хэдий ч бид нууцаар агнасаар байгааг энэхүү баримт харуулна. Өнгөрсөн жил л гэхэд нэг дор 200 гаруй тарвага хот руу оруулах гэж байгаад баригдсан тохиолдол бий. Энэ жил ч гэсэн постууд дээр тарвага хурааж авсан тухай мэдээлэл ирсээр байна. Наймдугаар сарын 14, 15-нд Баянзүрхийн товчоогоор иргэд тарваганы тулам оруулж ирэх гэж байсныг цагдаагийн ажилтнууд илрүүлсэн юм.

Хүмүүс тахлын халдвар авсан тохиолдлыг ажиглах дандаа анхаарал болгоомжгүйгээс болсон байдаг. 2015 онд гэхэд гурван хүн тахлын халдвар авч, хоёр нь амиа алдаж байв. Ховд аймгийн Булган суманд 16 настай хүүхэд нохой зууж ирсэн тарвагыг өвчиж байгаад гараа эсгэж, халдвар авсан. Улмаар эмнэлэгт оройтож хандсаны улмаас эмч нар амийг нь аварч чадаагүй юм. Түүнчлэн Хөвсгөл рүү аялахаар явсан нэгэн залуу замаасаа тарвага худалдан авч, чануулахаасаа өмнө биед сайн гээд эрхтнийг нь түүхийгээр залгивжээ. Үүнээсээ болоод халуурч эхлэхэд нь антибиотик ууж

явсаар цаг алдсан байдаг. Эцэс сүүлд нь эмнэлэг бараадсан ч хүлээн авахын үүдэнд амьсгал хураасан харамсалтай түүх бий. Хөдөө, орон нутагт хүн ам тархан суурьшсан болохоор тахал дэгдлээ ч газар авахуулалгүй дарах боломжтой. Харин дөрвөн уулын дундах жижигхэн хөндийдөө багшралдсан нийслэл хотод энэ аюул нүүрлэвэл юу болохыг төсөөлөөд үзээрэй. Хүн төрөлхтний түүхэнд тохиолдсон халдварт өвчнөөс хамгийн олон

● **Дөрвөн уулын дундах жижигхэн хөндийдөө багшралдсан нийслэл хотод энэ аюул нүүрлэвэл юу болохыг төсөөлөөд үзээрэй.**

● **Тарваган тахлын нян хөлдөөгчид бүтэн жилийн турш байсан ч устдаггүй, аюултай эд.**

● **Хэрэв цаг алдалгүй мэргэжлийн байгууллагад хандвал эдгэрэх бүрэн боломжтой.**

хүний амийг авч одсон нь тарваган тахал шүү дээ. Гэвч бид хөдөөнөөс тарваганы мах захин авчруулж идсэн хэвээр. Бас биед сайн гээд цөсийг нь залгина. Өнгөрсөн нэгдүгээр сард л гэхэд тахлын сэжигтэй тохиолдол илэрч, албаныхныг сандаргаад авсан удаатай. Хөдөөгөөс авчирсан тарваганы махаа жил шахам хөлдөөгчидөө хадгалсан эр түүнийгээ гарган жижиглэж байгаад хуруугаа эсгэсэн юм. Азаар тэр хүнээс тахлын шинж тэмдэг илрээгүй. Тарваган тахлын нян хөлдөөгчид бүтэн жилийн турш байсан ч устдаггүй, аюултай эд гэдгийг иргэд тэр бүр мэддэггүйн жишээ энэ.

Сүүлийн 20-иод жилийн статистикийг харвал 15-19 насны хөвгүүд тахлаар өвчлөх тохиол эрс нэмэгджээ. Аав, ах нарынхаа агнаж ирсэн тарвагыг өвчих үүрэг тэдэнд ихэвчлэн оногдоно. Ингээд өвчин явцдаа хуруу гараа санамсаргүй зүссэнээс болж өвчилдөг аж.

Хэрэв халдвар авбал 1-6 хоногийн дотор (ихэнхдээ 2-3 хоногт) шинж тэмдэг нь илэрдэг юм байна. Халдвар авсан бол халуурах, толгой өвдөх, бөөлжих, үе мөч, булчин өвдөх, амьсгалахад хүндрэлтэй болох зэрэг шинж тэмдэг илэрдэг. Хэрэв цаг алдалгүй мэргэжлийн байгууллагад хандвал эдгэрэх бүрэн боломжтой гэдгийг эмч нар сануулав. Харин оройтвол ямар ч авралгүй.

Бид л тарваган тахал гэж нэрлэдэг болохоос энэ халдвар зөвхөн тарвага биш, мэргэч бүх амьтнаас хүнд халдана. Тэр ч байтугай нохой, муур, тэмээ хүртэл халдварын нян тээх тохиолдол байдаг гэнэ. Африк, Ази, Өмнөд Америкийн орнуудад ихэвчлэн илэрнэ. Ялангуяа Африкийн ихэнх орон, Мадагаскар, Хятад, Орос, Казахстан, Монгол Улс аюултай бүс нутгийн тоонд орно. Мадагаскарт гэхэд ганцхан жилийн дотор 119 хүн тахлаар өвчилж, тэдний 40 нь нас барсан байдаг. Манай Монгол Улс Африк тив болон Мадагаскартай харьцуулахад өвчлөл харьцангуй бага. Гэхдээ хэнэггүй зангаа засахгүй бол хар тахлын аюул биднийг отсоор байх болно. [ZGM]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



Нийгэм

ЗГМ: ТОДРУУЛГА

Шинээр 13 цэцэрлэг ашиглалтад орно



Б.Ганбаяр / ЗГМ©

Өнөөдрийн байдлаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй засварын ажлын явц 54 хувийн гүйцэтгэлтэй бол нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажил 75 хувьтай байна.

Шинээр ашиглалтад оруулж буй барилга гурван жилийн баталгаатай

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Хичээлийн шинэ жилд нийслэлийн хэмжээнд төрийн болон төрийн бус өмчийн 241 сургуульд 31 мянга орчим хүүхэд нэгдүгээр ангид элсэн суралцана гэсэн тооцоо бий. Мөн өнөөдрийн байдлаар цэцэрлэгт 20 орчим мянган хоёр настнууд элсэхээр бүртгүүлээд байна. Үүнээс 11 мянган хүүхдийг цахимаар сонгон

авах бол үлдсэнийг хувийн өмчийн цэцэрлэгт үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр хамруулах тал дээр анхаарч байгаа албаны хүн онцлоо. Энэ жил нийслэлийн хэмжээнд ЕБС болон цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, ачааллыг бууруулах тал дээр ямар арга хэмжээ авч байгаа талаар нийслэлийн Боловсролын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хэлтсийн дарга Ж.Энхтөрөөс тодруулла.

-Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн ачааллыг бууруулах, хамрагдаж буй хүүхдийн тоог нэмэгдүүлэхэд хэрхэн анхаарч ажиллаж байна вэ?

-2017 онд нийт 10 сургууль, 13 цэцэрлэг шинээр барих болон өргөтгөлийн ажлыг хийхээр болсон. Өнөөдрийн байдлаар

улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй засварын ажлын явц 54 хувийн гүйцэтгэлтэй байна. Хан-Уул дүүрэг рүү худалдан авах ажиллагааны эрх шилжсэн 72 дугаар цэцэрлэгийн тендер шалгаруулалтын ажил үргэлжилж байна. Мөн Баянгол дүүргийн 47 дугаар, Хан-Уул дүүргийн 34 дүгээр сургуулийн засварын тендер шалгаруулалтад гомдол гарсан тул одоогийн байдлаар засварын ажил эхлээгүй. Харин нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын 75 хувийг гүйцэтгэсэн. Нийслэлийн төсвийн тодотголоор батлагдсан ажлын гүйцэтгэл 36 хувьтай байна.

-Нийт хэчнээн төгрөгийн хөрөнгө зарцуулж байгаа вэ?

-Улсаас нийт 1.6 тэрбум, нийслэлийн төсвөөс 600 сая төгрөг зарцуулахаар болсон. Үүнээс гадна нийслэлийн төсвийн

тодотголоор 521 сая төгрөгийг шинээр сургууль, цэцэрлэг барих болон өргөтгөл, засварын ажилд зарцуулахаар төсөвлөсөн.

Энэ жил 672 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, хамрагалтыг 77.6 хувьд хүргэнэ

-Хэчнээн хүүхэд хамрагдах боломжтой вэ?

-Өнгөрсөн жил төрийн болон төрийн бус өмчийн нийт 623 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, цэцэрлэгийн насны нийт хүүхдийн 72 хувь нь хамрагдсан. Харин энэ оны хичээлийн жилд нийт 672 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, цэцэрлэгт хамрагалтыг 77.6 хувьд хүргэнэ. Өнгөрсөн хичээлийн жилээс 5.6 хувиар өснө гэсэн тооцоо бий. Тиймээс сургууль, цэцэрлэгт шинээр ашиглалтад оруулах болон өргөтгөснөөр ерөнхий боловсролын 10 сургуульд нийт 7800, 13 цэцэрлэгт 1640 хүүхэд нэмж суралцах боломжтой болж

байгаа юм.

-Хэчнээн дүүрэгт сургууль, цэцэрлэг шинээр баригдаж байгаа вэ?

-Баянгол дүүргийн гурав, Баянзүрхийн 13, 18, 26, Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хороонд ерөнхий боловсролын сургууль шинээр барихаас гадна хуучин сургуульд өргөтгөл хийж байна. Харин Хан-Уул дүүргийн 10, 13, Сүхбаатарын 13, Чингэлтэйн хоёр, дөрөв, Баянзүрхийн 24, Сонгинохайрханы 17, 22 дугаар хорооны цэцэрлэгийг шинэчлэх болон шинээр ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

-Дээрх байршуудад сургууль, цэцэрлэгийн хүртээмж хэр байдаг вэ?

-Хүн ам ихтэй буюу Баянгол, Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт шинээр сургууль, цэцэрлэг барих болон өргөтгөлийн ажил хийгдэж байна. Мэдээж хэрэг эдгээр дүүргийн сургууль, цэцэрлэг маш их ачаалалтай ажиллаж байдаг. Тухайлбал, сургуулийн хувьд өнгөрсөн жил 36 сургууль гурван ээлжээр хичээллэж байсан. 2017-2018 оны хичээлийн жилд энэ тоог 27 болгон бууруулахаар төлөвлөсөн. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ТОО

926.4

Мянган төгрөг. Өрхийн нийгэм, эдийн засгийн энэ оны хоёрдугаар улирлын судалгаагаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 926.4 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс зургаан хувиар өслөө. Нэг өрхийн сарын бодит мөнгөн орлогын хэмжээ 896.3 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 22.4 мянган төгрөгөөр өсжээ.

» ХУРАЛ

Дэлхийн 40 орчим орны 200 гаруй нэрт яруу найрагч, зохиолч, нийтлэлч, орчуулагч, урлаг соёлын зүтгэлтэн Дэлхийн яруу найрагчдын 37 дугаар их хуралд оролцож байна. Өчигдөр эхэлсэн энэхүү хурал “Байгалийн оюун санаа ба Хүмүүний сэтгэлийн байгаль” хэмээх агуулгын дор зохион байгуулагдаж байгаа юм.

» ЭРҮҮЛ МЭНД

Говь-Алтай аймагт энэ жил хачигт халдварын 209 тохиолдол бүртгэгджээ. Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн мэдээлснээр халдвар авсан иргэдийг шинжилгээнд хамруулж байгаа аж.

» ХАНДИВ


ӨМӨЗО-ы Нийтийг аюулаас хамгаалах танхимаас Гадаадын иргэн, харьяатын газарт шаардлагатай 830 мянган юань буюу 303 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, хангамж хэрэгслийг гардуулжээ.

» БОЛОВСРОЛ

Монгол, ОХУ-ын хамтын ажиллагааны хүрээнд 2017-2018 оны хичээлийн жилд хойд хөршид 450 иргэнийг тэтгэлгээр суралцуулахаар болжээ. Цаашид энэ тоог 500 болгон нэмэгдүүлэх аж.

» ЭКОЛОГИ

Богдхан уулын ойн сангийн 76 хувь нь хөгширч, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдэж, үхцэтэй салхинд мод унах үзэгдэл сүүлийн жилүүдэд олширчээ. Учир нь хамгийн сүүлд 2014 онд цэвэрлэгээ хийснээс хойш гурван жил болсон. Тиймээс нэн даруй цэвэрлэгээ хийх шаардлагатай байгаа учир Ойн захиргааныхан БОАЖЯ-нд ханджээ.



БОЛОВСРОЛ

Сурах бичгийг есдүгээр сард тарааж дуусгана

Шинэ хичээлийн жилд нэг сая 241 мянга орчим сурах бичиг хэвлэн нийлүүлэхээр болжээ. Өнөөдрийн байдлаар ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын сурах бичиг сургуулиудад хүргэгдээд байна. Дунд, ахлах ангийн шинэ болон нөхөн хангалтын сурах бичгийг есдүгээр сард багтаан дуусгана гэж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны мэргэжилтнүүд хэллээ. Мөн энэ хичээлийн жилд VI-XII ангийн сурах бичгийн дундаж үнэ 2720 төгрөг байх аж. Өнөөдрийн байдлаар зарим сурах бичиг



худалдаанд гарсан бөгөөд энэ сарын 21-нээс ирэх сарын 15 хүртэл сурах бичгийн нэгдсэн

худалдаа Багшийн хөгжлийн ордонд зохион байгуулахаар болжээ. [ЗГМ]

ОРОН НУТАГ

Мал худалдан авахыг хориглолоо

Өмнөговь аймгийн удирдлагаас малын шилжилт хөдөлгөөнийг гурван жилийн хугацаатай хориглолоо. Тодруулбал, мал амьтны гоц халдварт өвчин буюу шүлхий, хонины цэцэг өвчний дэгдэлт улсын хэмжээнд зүүн болон төвийн бүсийн ихэнх аймгуудад гарч дэгдэлт буурахгүй байгаа тул дээрх шийдвэрийг

гаргасан байна.

Малын шилжилт хөдөлгөөнийг хориглосноор бусад аймгаас мал худалдан авах, тууварлах замаар өөрийн аймагт мал оруулж ирэхийг энэ сарын 12-ноос эхлэн зогсоожээ. Мөн мал амьтны гоц халдварт өвчний талаарх мэдээллийг малчдад хүргэж ажиллахыг аймгийн Онцгой

байдлын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар болон сумдын дарга нарт даалгасан байна.

Хэрэв хоригийг зөрчвөл иргэн, аж ахуй нэгжид хуулийн дагуу арга хэмжээ авахыг аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газарт үүрэг болгожээ. [ЗГМ]

Би үйлдвэрлэгч



Сэтгэлд нийцсэн, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд гурван жилийн дадлага, сургуулилт шаардлагатай. Бид ашиг олохын тулд богино хугацаанд хямдхан бүтээгдэхүүн хийж болох ч чанарыг эрхэмлэж байна.

Б.Ганбаяр / ЗГМ©

Тансаг хэрэглээний шинэ загвар

Өмчийн эрхийг хамгаалахдаа Монгол Улс АНУ-аас илүү

Ингээд ваннаа чанартай хийж сурахын тулд 14 жил уйгагүй оролдсоны эцэст санаандаа хүртэл хийж чаддаг болсон. Монголд ирэхээсээ өмнө Орост хэсэг хугацаанд амьдарч байсан. Харин одоо Баян-Өлгий аймагт гэр бүлийнхээ хамт амьдарч, үйлдвэрлэл явуулж, бүтээгдэхүүнээ экспортолж байна. Миний нэг зорилго орон нутгийг хөгжүүлж, валютын урсгалыг нэмэгдүүлэх. Би Америкт байхдаа найман жил Нью-Йоркийн хувьцааны компанид ажилласан. Тиймээс эдийн засгийн талаар тодорхой мэдлэг, ойлголттой учир энэ салбарт хүч үзэж байна.



-Та 14 жил оролдсоны эцэст санаандаа хүрсэн ванн урладаг болсон гэлээ. Модоор ванн хийхэд гарын үр дүй шаардагддаг болов уу. Монголчуудад ванн хийх арга туршлагаасаа зааж сургаж байгаа юу. Мөн түүхий эдээ хаанаас авдаг вэ?

-Түүхий эдийн тухайд зарим материалаа Монголоос, бусдыг нь Оросоос импортлодог. Монголд ирчихээд анхны ваннаа хийхээр мод хайж байсан юм. Тэгсэн хэсэг хүмүүс ойд унасан, хэрэгцээгүй болсон модыг банз болгож, зүсэх гэж байсныг нь аваад анхны ваннаа хийж байлаа. Нэг ванн хийхэд маш их хугацаа ордог. Сайн ванн, сайн бүтээл хийхэд тэвчээр хэрэгтэй гэж боддог. Үүнийг ч эрхэм болгож, намайг дагалдаж байгаа монгол залуучуудад хамгийн гол нь тэвчээр гэж үргэлж хэлдэг. Тэдэнд яарахгүй, хамгийн сайн бүтээл урлахыг заадаг. Бүтээгдэхүүн бэлэн болсны дараа АНУ руу экспортлодог. Харин Монголд Tempini хэмээх тансаг зэрэглэлийн тавилгын дэлгүүрийн үзүүлэнд ваннаа тавьсан байгаа. Улаанбаатар хотод загвар тавих боломжтой хэд хэдэн дэлгүүр байдаг боловч бид Tempini-г сонгосон. Учир нь Италийн гангиг чулуун шалны плита зэрэг манай бүтээгдэхүүнтэй эн зэрэгцэхүйц тансаг зэрэглэлийн барилгын материал тэднийд байдаг.

-Тансаг зэрэглэлийн брэнд зах зээлд эрэлт хэрэгцээтэй байна. Хэдийгээр Монголд эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй байгаа ч хүмүүс тансаг зэрэглэлийн бараа бүтээгдэхүүн худалдан авч байна. Та бүтээгдэхүүнээ ихэвчлэн гадагшаа гаргадаг гэж байна. Монгол хэрэглэгч танай бүтээгдэхүүнийг худалдан авч байна уу?

-Одоогоор Монголд нэг ч ванн зараагүй байна. Tempini дэлгүүрт загвараа тавиад удаагүй байна. Энэ жилээс хамтарч ажиллаж байгаа учир үр дүн гарна гэж бидэнд ч зах зээл байна гэж харж байна. Удахгүй монголчууд модон ванн хэрэглэх цаг ирнэ. Энэ бол цаг хугацааны асуудал.

-Америк хэрэглэгчийн гар дээр очих хүртэл бүтээгдэхүүний үнэ хоёр дахин өсөж байгаа байх. Тэврийн асуудлаа хэрхэн шийдэж байна вэ?

-Манай захиалагчдад үнэ төдийлэн чухал биш. Найз нөхөд болон ойр тойрныхонд нь байдаггүй учраас бидний үйлдвэрлэсэн ванныг худалдан авах сонирхолтой байдаг. АНУ-д модон ванн 8000 ам.долларын үнэтэй. Тэдэнд тэврийн зардалд 1000-2000 ам.доллар төлөх нь тийм ч том асуудал болдоггүй. Бид ваннаа Монголоос гадна АНУ-д үйлдвэрлэж байгаа.

-Таныг модоор шат, ширээ, сандал хийдэг гэж дуулсан. Монголд энэ төрлийн бүтээг-

дэхүүний зах зээл ямар байна вэ?

-Модон шат, тавилгын хувьд борлуулалт харьцангуй сайн. Баян-Өлгийд гэхэд байшингийн шатыг хийхдээ тооцоог яаж зөв гаргах, шатаа хэрхэн зөв хийх тал дээр суралцах зүйл их байна. Тиймээс АНУ-аас мэргэжлийн хүмүүс авчирч, монгол мужаануудад сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Аравдугаар сард шат хэрхэн зөв хийхийг заахаар мэргэжлийн хүн ирэх гэж байна. Хамгийн сонирхолтой нь, Монголын зах зээлд модон ванн, хаалга, ширээ, сандалнаас илүүтэй шат эрэлт хэрэгцээтэй байдаг нь ажиглагдсан. Чанартай модоор, сайн шат хийх мэргэжлийн хүн ховор байдагтай энэ нь холбоотой байх.

● **Түүхий эдийн тухайд зарим материалаа Монголоос,бусдыг нь Оросоос импортлодог.**

● **Манай захиалагчдад үнэ төдийлэн чухал биш.**

● **Ваннаа чанартай хийж сурахын тулд 14 жил уйгагүй оролдсоны эцэст санаандаа хүртэл хийж чаддаг болсон.**



-Монголд бизнес эрхэлж байгаа хүний хувьд манай бизнесийн орчинг хэрхэн дүгнэж байна вэ?

-Би АНУ, ОХУ, Монгол гээд гурван оронд амьдарч үзсэн. Эрх чөлөө, нээлттэй байдал, худалдаа үйлдвэрлэл эрхлэх чадвараараа АНУ-ыг Монголтой харьцуулж болно. Миний хувьд өмчийн эрхийг хамгаалах үзэл баримтлалыг дэмжигч нэгэн. Харин Орост өмчийн эрхийг хамгаалах бодлого, журам хангалттай түвшинд хэрэгждэггүй. Энэ нь бизнес эрхлэгчдэд, ялангуяа олон улсын компаниудад дарамт болдог. Харин Монголд нөхцөл байдал харьцангуй дээр шүү. Мэдээж хэрэг өмчийн эрх тал дээр сайжруулах олон зүйл байгаа. АНУ-тай харьцуулахад өмчийн эрхийг хамгаалах тал дээр Монгол илүү гарна. Түүнчлэн Монголын татварын хэмжээ маш бага төдийгүй хэдийг төлөх вэ гэдэг асуудалд үргэлж санаа зовохгүй байгаа нь бизнес эрхлэхэд илүү

таатай санагддаг.

-Монгол Улсад хэрэгжүүлэх бизнесийн өөр санаа байна уу. Эсвэл одоо эрхэлж байгаа үйлдвэрлэлээ өргөжүүлэх тал дээр анхаарч байна уу?

-Мэдээж хэрэг одоогийн үйлдвэрлэлээ өргөжүүлэх бодолтой байгаа. Гэхдээ үүнд цаг хугацаа хэрэгтэй. Хурдан хугацаанд бизнесээ өргөжүүлнэ гэвэл их хэмжээний зээл авах шаардлагатай болно. Гэтэл би өртэй байх тийм ч дуртай биш. Сэтгэлд нийцсэн, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд гурван жилийн дадлага, сургуулилт шаардлагатай. Бид ашиг олохын тулд богино хугацаанд хямдхан бүтээгдэхүүн хийж болох ч чанарыг эрхэмлэж байна. Гэхдээ санаа багаар үйл ажиллагаагаа өргөжүүлэх зарчим баримталж байна. Харин бизнесийн нэг шинэ санаа төрсөн шүү. Юу гэхээр, Монголд сайн чанарын мод хайж байгаа хэрэглэгчид олон байна. Тиймээс модны импортын тал

дээр бизнесээ тэлэх боломжтой гэж харж байгаа. Гэхдээ яарахгүй байна. Хэдий чинээ хурдан өргөжнө, төдий чинээ унах магадлал өндөр байдаг шүү дээ.

-Зах зээл бол хэрэглэгчид. Тиймээс хэрэглэгчдийн юу хүсэж байгааг мэдэх нь чухал болов уу. Монголын худалдан авагчдын нийтлэг зан байдлыг ажигласан уу?

-Ажигласан. Гэхдээ энэ зан байдал нь дэлхийн хаана ч түгээмэл байдаг. Хүмүүсийн дийлэнх нь эхлээд ванныг хараад "хөөх" гэж дуу алддаг ч үнийг нь хараад л дургүйцдэг. Гэхдээ манай ванн хүн бүрт зориулагдаагүй. Чанартай, хийц сайтай, магадгүй дэлхийд шилдэгт тооцогдох бүтээгдэхүүнд мөнгө төлөх хүсэлтэй хүмүүст л зориулсан. Тэрчлэн олон нийтэд зориулсан том үйлдвэртэй болох сонирхол надад байхгүй. Гараар үйлдвэрлэсэн, ганц ширхэг бүтээгдэхүүн чанар, баталгаа, өндөр үнийг илтгэдэг. [ЗГМ]



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН

[МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛААС ЧУХЛЫГ НЬ]

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.



Дэлхийн хэмжээнд Засгийн газрын бондууд хямралаас хойш 48.8 хувийн ашиг авчирсныг Bloomberg Barclays индекс харуулж байна.

оруулагчид тогтвортой өгөөж эрэлхийлдэг. Үүний үр дүнд хямралын дараах эрсдэлтэй бондууд амжилттай зарагдаж, шинэ зах зээл рүү мөнгө цутгаж, хувьцааны индексүүд дээд түвшинд хүрснээр урьд үзэгдээгүй бага хэлбэлзэлтэй үе ирсэн юм. Дэлхийд хөрөнгийн менежментээр тэргүүлэгч BlackRock компанийн стратеги судлаач Ричард Торнилл “Таамаглаагүй хямралаас зайлсхийхийн тулд бондын өгөөжийг багасгаж, 35 жил үргэлжилсэн өсөлтийн зах зээлийн эрин төгсөж буйг бид харж байна” гэжээ.

Хэдийгээр мөнгөний зөөлөн бодлого хөрөнгийн үнэ өсөхөд түлхэц өгсөн боловч энэ нь Засгийн газрын бондын үнэд нөлөөлсөн ганц хүчин зүйл бус гэж ноён Торнилл үзэж байна. Тэрбээр санхүүгийн хямралаас хойш зохицуулалтад хийсэн өөрчлөлт зарим хөрөнгө оруулагчийг өндөр чанартай зээлийн хөрөнгө хуримтлуулахад хүргэсэн. Ялангуяа шинэ зах зээлүүдэд дунджаас доогуур эдийн засгийн болон бүтээмжийн өсөлт ажиглагдсан ба хуримтлалын түвшин дээшилжээ. Ноён Торнилл цааш нь “Бидний таамагаар бодлого аажмаар хэвийн болох тул бондын өгөөж маш аажим дээшилнэ” хэмээн өгүүллээ. Холбооны нөөцийн 4.47 их наяд ам.долларын тэнцлийн талаас илүү нь Сангийн яамны өрийн бичгээс бүрддэг. Үүнд Засгийн газрын баталгаатай мөргөжлийн зээлийн үнэт цаас 40 хувийг эзэлж байна.

Төв банкуудын бонд худалдан авалт улсын үнэт цаасны өгөөжийг маш доогуур, заримдаа бүр хасах үзүүлэлт рүү оруулсан бөгөөд зарим бонд эзэмшигч үнэт цаас худалдан авснаах төлөө Засгийн газарт хүү төлж буй. Дэлхийн хэмжээнд Засгийн газрын бондууд хямралаас хойш 48.8 хувийн ашиг авчирсныг Bloomberg Barclays индекс харуулж байна. Өнгөрсөн оны тайлангаас үзэхэд хөрөнгө худалдан авах хөтөлбөрийн үр дүнд Европын Засгийн газрын бондын өгөөж 13 суурь нэгжээр буурсан юм. Өгөөж буурч, үнэ өсөж байна.




Бондын өгөөж буурч үнэ өсөж байна

Японы банкны тэнцэл бас Холбооны нөөцийнхөөс давж, 4.53 их наяд ам.долларт хүрснээс 85 хувь нь Японы Засгийн газрын үнэт цаас аж. Холбооны нөөцийн баланс түүхэндээ хэд дахин өссөн ч дэлхийн II дайны үед зах зээлийн байдлыг сайжруулахын тулд өрийн бичгүүдийг ихээр худалдан авсан байдаг. Гэвч өнөөгийн нөхцөлд түүхэнд анх удаа ийм олон төв банк арван жилийн хугацаанд харилцан уялдаатай үлэмж хэмжээний худалдан авалт хийсэн юм.

руулагчдын толгойны өвчин болж, дэлхийн эдийн засгийн мөнгөний бодлогыг хэвийн нөхцөлд буцаах асуудал үүсэв. Ирэх долоо хоногт Жаксон Хоулд дэлхийн томоохон мөнгөний бодлого тодорхойлогчдын жил бүрийн уулзалт болохын өмнөх үед ЕТБ-ны ерөнхийлөгч Марио Драги Евро бүсэд хоёр их наяд ам.долларын бонд худалдан авах хөтөлбөрөөс гарах бодолтой байгаа эсэхийг зах зээл ажиглаж байна.

Холбооны нөөцийн долдугаар сарын тайлан лхагва гарагт нийтлэгдсэнээс үзэхэд тус банк мөнгөний бодлогын байр сууриа чангатгах дохио



өглөө. Вашингтонд байрлалтай Бруксинсын хүрээлэнгийн татвар, мөнгөний бодлогын төвийн захирал Дэвид Вессел ярихдаа бодлого боловсруулагчид 2013 онд оролцох гээд “хуруугаа түлсний”

дараа энэ удаа мөнгөний зөөлөн бодлогоос маш болгоомжтой гарч эхэлж байж магадгүйг онцолжээ. Тэрбээр “Драги, Йеллен (Холбооны нөөцийн захирагч) нар мөнгөний бодлогын талаар дохио

өгөхийг хүсвэл Жаксон Хоулын уулзалт зах зээлд маш чухал мөч” болохыг тэмдэглэв. Төв банкуудын бонд худалдан авалт дэлхий даяар зах зээлд хүчтэй нөлөөлдөг ба хөрөнгө

Хятад улс АНУ-ын хамгийн том зээлдүүлэгч боллоо



АНУ-ын Сангийн яамны 1990 онд гаргасан бондын загвар.

Жоэ Реннисон АНУ-ын Засгийн газрын шинэ тайлангаас үзэхэд Хятад улс Японыг ардаа орхиж, Америкийн хамгийн том зээлдүүлэгчийн байр сууриа эргүүлж авлаа. Бээжин өнгөрсөн онд юанийг хамгаалахаар гадаад валютын нөөцийнхөө зарим хэсгийг зарцуулсны дараа аравдугаар сард Америкийн Сангийн яамны үнэт цаасны гадаадын хамгийн том зээлдүүлэгч гэсэн нэрээ Японд алдсан билээ. Гэвч тэр үеэс хойш Хятадын мөнгөн тэмдэгт тогтворжиж, улмаар 2017 оны эхэнд нэг ам.доллар 6.950 юаньтай тэнцэж байснаа энэ мягмар гарагт 6.6855 болжээ.

нэмэгдүүлсэн боловч өнгөрсөн жилийн мөн үеийн түвшинээс 94 тэрбумаар бага байна” гэжээ. Гадаадын төв банкууд болон хөрөнгө оруулагчид худалдан авах, зарах нь АНУ-ын Засгийн газрын бондын зах зээлд ихээхэн нөлөөтэй. 10 жилийн хугацаатай бенчмарк бондын өгөөж гуравдугаар сард жилийн дээд хэмжээ буюу 2.63 хувьд хүрсэн бол зургадугаар сард хамгийн доод түвшин 2.13 хувь руу унаж, мягмар гарагт 2.27 хувиар хаагдсан байна. Японы гарт буй АНУ-ын бондын эзэмшил аажмаар буурч байгаа хэдий ч өнгөрсөн оны аравдугаар сард хамгийн том зээлдүүлэгч болсон. MUFU-ын стратегич Жон Херман “Японы тал маш болгоомжилж байгаа. Тэд АНУ хүүгээ өсгөнө гэж үздэг. Иймээс тэд хамгийн өндөр үнэтэй байхад нь худалдан авахыг хүсэхгүй” гэжээ.

Эрик Платт Amazon компани энэ онд гуравдугаарт бичигдэх их хэмжээний компанийн бондын арилжаагаа мягмар гарагт дуусгав. Хүнсний бүтээгдэхүүний Whole Foods-ийг өөртөө нэгтгэж буй тус компани санхүүжилтэд шаардлагатай 16 тэрбум ам.долларыг ийнхүү амжилттай хуримтлуулж чадлаа.

Жэфор Бээос үндэслэн байгуулсан Amazon компани 3-40 жилийн хугацаатай долоон хэсэг зээл ашиглан хөрөнгө босгохоор төлөвлөж байна. Олон тэрбум ам.долларын үнэтэй арилжааны захиалгын хэмжээ Нью Йоркод өглөөний 11 цагийн байдлаар 23.5 тэрбумд хүрснийг арилжаанд оролдож буй хоёр ч хөрөнгө оруулагч өгүүлсэн юм.

AT&T, British American Tobacco, Tesla зэрэг компанийн өрийн бичгийн арилжаа хэдэн долоо хоногийн турш зах зээлийг дарсны дараа Amazon уг арга хэмжээг авчээ. Өгөгдлөөр хангах үйлчилгээ эрхэлдэг Dealogic-ийн судалгааг үзвэл компаниуд энэ онд АНУ-ын өрийн зах зээлээс 1.2 их наяд ам.доллар хуримтлуулсан нь шинэ үнэмлэхүй амжилт болж байна.

Аварга хэмжээтэй энэ удаагийн наймаа нь хамгаалах байр сууринд шилжсэн үнэт цаасны зах зээлээс болж сулраад байгаа зээлийн зах зээлд шинэ дарамт болов. S&P 500-д багтдаг аваргууд өнгөрсөн долоо хоногт үнэт цаасны зах зээлд хүлээсэн алдагдлын хэмжээ энэ оны гуравдугаар сараас хойш тохиолдож байгаагүйгээр өслөө.

“Өнгөрсөн долоо хоногт өөрт минь сургамж болсон гол зүйл бол хөрөнгө оруулалтын зах зээл эмзэг байгаа явдал. Зах зээлд Волл Стрит өдөр бүр шинэ бэрхшээл тулгасаар” хэмээн BNP Paribas Investment Partners-ийн багцын менежер Эндрю Форсайт тайл-



Amazon 16 тэрбум ам.долларын бонд гаргав

барлав. “Зах зээл таагүй байхад андеррайтерууд завгүй, ажилтай байгааг харалгүй уджээ” хэмээн тэрбээр нэмж өгүүлсэн юм.

Хөрөнгө оруулалтын зэрэглэл бүхий компанийн бонд, Засгийн газрын бонд хоёрын өгөөжийн зөрүү сүүлийн найм хоногт долоон суурь нэгжээр ихсэж, 115 болсныг Bank of America Merrill Lynch-ийн өгөгдөл харуулж байна. Энэ долдугаар сард 355 суурь нэгж байсан эрсдэл бүхий өгөөж ихтэй бондынх 389 болж “үсэрлээ”.

“AT&T, British American Tobacco-гийн бонд сонирхсон хөрөнгө оруулагчид сүүлийн хэд хоногт ихэссэнээс ачаалал үүслээ. Дээр нь Умард Солонгосын заналхийлэл ихэссэн” хэмээн Invesco-гийн багцын менежер Мэтт Брилл тайлбарлав. Тэрбээр “Зах

зээл эмзэг байгаа ч энэ удаагийн наймаа урагштай боллоо” хэмээн өгүүлсэн юм.

Whole Foods-ийг худалдан авсан нь Amazon-ы хүнсний бизнест “хөшүүрэг” болно хэмээн зээлийн үнэлгээний Moody’s агентлагийн шинжээч нар үзэж байна. Amazon-ы хувьд ядаж л хүнсний салбарт дан онлайн бус, бодит дэлгүүр хоршоо үүсэж байгаа нь тус компанийн өсөлтийн стратегид тустай”-г шинжээчид дурдлаа.

Amazon нь Moody’s агентлагийн зэрэглэлээр эерэг төлөв бүхий Baa1 үнэлгээтэй. Энэ нь junk буюу ашиггүй хязгаараас гуравхан шаг дээгүүр байгаа юм. Харин үнэлгээний өрсөлдөгч байгууллага S&P Global-ынхаар AA үнэлгээтэй.

Урьд нь Amazon компани 2014

онд 5-30 жилийн хугацаатай, зургаан тэрбум ам.долларын бонд гарган өрөө өсгөсөн. Тухайн үед тус компанийн 10 жилийн бондын өгөөж 3.84 хувьтай байсан юм. Харин мягмар гарагт тус компани 110 суурь нэгж буюу 3.36 хувийн өгөөж бүхий 10 жилийн хугацаатай бонд илүүтэй арилжжээ.


Whole Foods-ыг мэдэлдээ авах арилжаа ирэх хоёрдугаар сарын дундуур эцэслэн шийдэгдэж чадахгүй бол Amazon мягмар гарагийн арилжаанаас хуримтлуулсан хөрөнгийг компанийн ерөнхий үйл ажиллагаанд зориулна. Энэ талаар андеррайтер банкуудаас хөрөнгө оруулагч нарт илгээсэн үнийн тайлбарын захидалд өгүүлсэн байна.



Эдийн засаг

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Хөрөнгө оруулалтын хүч



Эдийн засгийн "эрүүл мэнд"-ийг тодорхойлох статистик үзүүлэлт дөнгөж гаргасан талх шиг халуун байна.

С.Батсайхан / ЗГМ©

Төлбөрийн тэнцлийн алдагдал хоёр дахин буурчээ

Тайлант улиралд гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниуд ашигтай ажилласан нь төлбөрийн тэнцэлд голлон нөлөөлсөн. Энэ нь төлбөрийн тэнцлийн богино болон дунд хугацааны төлөв эерэг байгааг улам тодотголоо. Урсгал болон хөрөнгийн дансны

тэнцэл 265.2 сая ам.долларын алдагдалтай гарсан. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 44 хувиар буюу 210.8 сая ам.доллараар буурчээ. Төлбөрийн тэнцлийн алдагдал агшихад санхүүгийн дансны тэнцэл 353.4 сая ам.доллараар ашигтай гарч, жилийн өмнөх үеийн үзүүлэлтээс 40 хувиар буурсан нь багцын хөрөнгө оруулалт өсөлттэй гарахад нөлөөлжээ. Тодруулбал, санхүүгийн дансны тэнцэл 236.7 сая ам.доллараар буурсан байна. Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө болон санхүүгийн тэнцлээс бүрддэг. Урсгал

тэнцлийн алдагдлыг хөрөнгө болон санхүүгийн тэнцлийн ашиг далдалж, төлбөрийн тэнцэл харьцангуй тогтворжиж ирлээ. Өөрөөр хэлбэл, урсгал тэнцлийн алдагдлыг хөрөнгө болон санхүүгийн тэнцлийн ашгаар нөхөж байна. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл нь хоёр үндсэн эх үүсвэртэй. Нэг нь гадаадын шууд хөрөнгө оруулалт бол хоёр дахь нь Засгийн газрын гадаадаас авсан зээл ордог.

Хөгжиж буй орнууд капитал хөрөнгө оруулалтыг дэмжиж, гаднаас зээл авах замаар богино хугацаанд урсгал тэнцлийн алдагдлаа санхүүжүүлж байна.


Манай улсын хувьд төлбөрийн тэнцлийн алдагдлаа хумихад гадаадын шууд хөрөнгө оруулалт хамгаас чухал болчихоод байна. Хэдий урсгал тэнцлийн алдагдал харьцангуй өндөр биш боловч өрийн дарамт хэвээр. Ийм үед гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч байгаа нь олзуурхах мэдээ. Гадаад худалдаа энэ оны долдугаар сарын байдлаар 1.2 тэрбум ам.долларын ашигтай гарч, экспортын орлого нэмэгдэж байгаа нь бизнесийн орчинд эерэг дохио болов.

Урсгал тэнцлийн алдагдал нь энгийн үгээр хэлбэл манай улсын гадаадад гаргаж буй

бараа, үйлчилгээ, шилжүүлгийн төлбөрийн хассан цэвэр дүн. Өөрөөр хэлбэл, бид юуг бүтээж, валютын ямар орлого олов, юуг гаднаас авч, ямар хэмжээний валютын төлбөр гадагш нь төлөв гэдгийг харуулдаг эдийн засгийн суурь үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт хасах утгатай байна гэдэг нь бидний олж байгаа валютын орлого нь бидний гадагш төлдөг валютын хаана ч хүрдэггүй гэсэн үг. Гэхдээ эдийн засаг энэ оны эхний хагас жилд 5.3 хувиар өсөж, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж байна. Энэ нь төлбөрийн тэнцлийн алдагдал цаашид хумигдах утгал. [ЗГМ]

БИЗНЕСИЙН ОРЧИН

Борлуулалтын менежерүүдийн индекс 51 нэгж болов



Н.Алтан
Шинжээч

"World Economics" байгууллагаас Монголын борлуулалтын менежерүүдийн индексийг наймдугаар сарын байдлаар танилцуулла. Өнгөрсөн сард 54.6 нэгжид хүрч өсөж байсан энэхүү индекс наймдугаар сард 51 нэгж болж буурсан. Ийнхүү буурсан ч борлуулалтын менежерүүдийн индекс өсөлтийн бүсэд хадгалагдсан хэвээр байгаа юм. Мөн бизнесийн итгэлийн индекс

сүүлийн саруудын өндөр өсөлтөө хадгалсан хэвээр байгааг "World Economics" байгууллага онцолсон байна. Гэвч өнгөрсөн сард сүүлийн гурван жилийн хамгийн өндөр түвшинд хүрсэн байсан зах зээлийн өсөлтийн индекс 50 нэгжээс доош буурсан дүнтэй гарлаа.

Бас нэг онцлох үзүүлэлт бол хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт байна. Сүүлийн 40 сар дараалан буурсан хөдөлмөр эрхлэлтийн индекс наймдугаар сард өссөн дүнтэй гарсныг "World Economics" байгууллага онцлолоо. [ЗГМ]

үзүүлэлтийг харвал, долдугаар сард нийт бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 3.4 мянган хүнээр буюу 11.3 хувиар буурчээ. ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжийн санхүүжилтүүд орж ирж, гадаад валютын нөөц нэмэгдэж буй. Энэ нь бизнесийн төдийгүй хөрөнгө оруулагчдын итгэлд эергээр нөлөөлж байгааг салбарын шинжээчид мэдэгдэж байгаа юм. Мөн Монгол Улсын эдийн засгийн хүндрэлээс гарах үйл явц үргэлжилсээр байгаа гэдгийг "World Economics" байгууллага онцлолоо. [ЗГМ]

дэлхий ХБНГУ-ын эдийн засгийн ерөнхий үзүүлэлт сайн байна

Г.Илч
ЗГМ

Европын хамгийн хүчирхэг эдийн засагтай ХБНГУ-ын эдийн засаг өссөөр байна. Энэ оны хоёрдугаар улиралд тус улсын эдийн засаг 0.6 хувиар тэлжээ. Хэдийгээр энэ үзүүлэлт шинжээчдийн таамаглаж байсан

0.7 хувьд хүрээгүй ч өсөлтөө хадгаллаа. Эдийн засгийн үзүүлэлт Германы Ерөнхий сонгуулийн кампанит ажилтай давхцаж гарснаараа онцлогтой байсан. Ийнхүү ДНБ-ий өсөлт харьцангуй сайн гарсан нь одоогийн эрх баригчдын ялах магадлалыг улам нэмэгдүүлж байгааг шинжээчид онцолж байна. Хамгийн сүүлд явуул-

сан санал асуулгаар Канцлер Ангела Меркель гол өрсөлдөгч Социал Демократ намын Мартин Шулцээс 17 хувь илүү байгааг тогтоожээ. Ямартай ч Герман улсад ажилгүйдэл буурч, хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал Евро бүсийн орнууд дундаа харьцангуй сайн үзүүлэлттэй байна. [ЗГМ]

СТАТИСТИК

Төсвийн алдагдал гурав дахин буурлаа

Б.Мөнх
ЗГМ

Эдийн засагт дарамт болж байсан төсвийн алдагдал агшиж байна. Өнгөрсөн оны долдугаар сард 1.9 их наяд төгрөгт хүрээд байсан төсвийн алдагдал энэ оны долоон сард 1.4 их наяд төгрөгөөр буурав. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 589.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн орлого 28.3 хувиар өссөн нь алдагдал багасах үндэслэл болжээ. Үүнээс гадна Засгийн газар зардлаа 10.5 хувиар танахан нь төсвийн алдагдал буурахад нөлөөлөв. Орлого нэмэгдэж, зарлага буурснаар дунд хугацаанд төсөв ашигтай гарах боломжтой гэсэн үг. Ингэснээр эдийн засагт тулгарч буй төсвийн хямрал холдох юм. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр, татварын нийт орлого 3.4 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26.4 хувиар өсжээ. Улсын нэгдсэн төсвийн орлогын 78.1 хувийг татварын орлого эзэлсэн байна. Татварын орлогыг

задалж харахад, нэмэгдсэн өртгийн албан татвар болон орлогын албан татварын орлого 43-52 хүртэлх хувиар өсжээ.

Төсвийн алдагдал буурч байгаа нь орлого, зарлагын түвшин тэнцвэржих нөхцөл болж байна. Тэрчлэн экспортын орлогыг бүрдүүлэх уул уурхайн эрдэс түүхий эдийн үнэ тогтвортой төдийгүй өсөж байгаа нь дээрх боломжийг бэхжүүлэх болов. Манай улс энэ он гарсаар 1.1 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний нүүрс экспортжээ. Нүүрсний экспорт оны эцэст хамгийн багадаа 21 сая тонн хүрэх төлөвтэй байна. Нийт экспорт огцом өсөхөд жин дарсан нүүрсний 97 хувийг БНХАУ-д нийлүүлжээ. [ЗГМ]



ЗГМ ТОВЧХОН

» МОНГОЛБАНК

604

Тэрбум төгрөг. Монголбанк нэг долоо хоногтой 604 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжааллаа. Ингэснээр төв банкны үнэт цаасны үлдэгдэл 1.5 их наяд төгрөгт хүрээ.

БАНК, САНХҮҮ

8.8


Хувь. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 1.1 их наяд төгрөг болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.8 хувийг эзэлж байна.

ӨРХИЙН ТӨСӨВ

7.3

Хувь. Улсын хэмжээнд хамгийн ядуу бүлгийн хүн амын хэрэглээ нийт хэрэглээнд 7.3 хувийг, хамгийн чинээлэг бүлгийн хүн амын хэрэглээ 42.1 хувийг эзэлж байна. Энэ нь хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхны хэрэглээний дундаж хэмжээ хамгийн ядуу 20 хувийнхаас 5.8 дахин их байгааг харуулж байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ



1.7

Их наяд төгрөг. Монголын хөрөнгийн биржийн "MSE ALL" индекс лхагва гарагт 925.75 нэгж болж, 0.65 хувиар өсөв. Ингэснээр зах зээлийн үнэлгээ 1.7 их наяд төгрөгт хүрчээ. Энэ өдөр "Стандарт ноос" компанийн хувьцааны ханш хамгийн өндөр буюу 2.56 хувиар өссөн бол "Э-Транс логистик" компанийнх 10.37 хувиар уналаа.

ХӨРШ

6.4

Хувь. БНХАУ-ын 2020 он хүртэлх эдийн засгийн өсөлтийн төлөвийг ОУВС нэмэгдүүлжээ. Гэхдээ тус улсын санхүүгийн зах зээлд өр төлбөр нэмэгдэж, өсөлтөд дунд хугацааны эрсдэл үүсэж болзошгүй байгааг сануулжээ. ОУВС-гийн тооцоогоор урд хөршийн эдийн засгийн жилийн өсөлт 2020 он хүртэл дунджаар 6.4 хувьтай байх нь.

ДЭЛХИЙ

35

Хувь. Шинэ төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Сингапурт орон сууцны борлуулалт өнгөрсөн сард 35 хувиар өсжээ.

ВАЛЮТЫН ХАНШ

Ам.доллар	2444.19
Евро	2863.86
Япон иен	22.04
ОХУ рубль	40.96
БНХАУ юань	365.13
БНСУ вон	2.14

МЭДЭЭЛЛИЙН ЧАНАР АМЖИЛТЫН ҮНДЭС

Microsoft Dynamics NAV ERP системийг Монголд

INTER SOLUTIONS MANAGEMENT LLC
УТАС: +976 76009293
support@ism.mn